



Дэлхийн
Хөрсний
Өдөр

ХӨРСӨӨ ХАЙРЛАН
ХАМГААЛЪЯ

ХЭМЖЬЕ, ХЯНАЯ, УДИРДЪЯ



Хөрс хамгааллын бодлого, хөрсний тогтвортой менежмент сэдэвт

МОНГОЛ ОРНЫ ХӨРС СУДЛАЛ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

2024 оны 12 сарын 5 | УЛААНБААТАР



Монгол Улсын
Их Сургууль



Газарзүй,
Геоэкологийн
хүрээлэн



Хөдөө Аж Ахуйн
Их Сургууль



Байгаль орчин, уур
амьсгалын
өөрчлөлтийн яам



Хүнс, хөдөө аж
ахуй, хөнгөн
үйлдвэрийн яам

Хөрс хамгааллын бодлого, хөрсний тогтвортой менежмент сэдэвт

МОНГОЛ ОРНЫ ХӨРС СУДЛАЛ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

2024 оны 12 сарын 5 | Улаанбаатар

Монгол Улсын Их Сургуулийн Номын сан 502 хурлын танхим

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Монгол Улсын Их Сургууль,
Газарзүй-Геоэкологийн хүрээлэн (ШУА),
Хөдөө Аж Ахуйн Их Сургууль

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам,
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

ОРОЛЦОГЧ



Ланд Овнер ХХК



Нийслэлийн
Байгаль орчны
газар



Газар зохион
байгуулалт,
геодези,
зураг зүйн
ерөнхий
газар



Ургамал газар
тариалангийн
хүрээлэн



Нийгмийн эрүүл
мэндийн
үндэсний төв



Биологийн
хүрээлэн

Хөрс хамгааллын бодлого, хөрсний тогтвортой менежмент сэдэвт

“МОНГОЛ ОРНЫ ХӨРС СУДЛАЛ – 2024”

эрдэм шинжилгээний хурал, уулзалтын удирдамж

Үндэслэл:

“Дэлхийн хөрс судлалын холбоо” болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага /ХХААБ/ хамтран 2012 оноос “Дэлхийн хөрсний өдөр”-ийг жил бүрийн 12-р сарын 5-ны өдөр тэмдэглэж байх санаачилгатай холбогдуулан уг эрдэм шинжилгээний хурлыг хөрс судлалын тодорхой сэдвийн хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн.

Дэлхийн ХХААБ-аас 2024 оны Дэлхийн хөрсний өдрийг "Хөрсийг хайрлан хамгаалъя: хэмжье, хяная, удирдъя" сэдвийн хүрээнд зохион байгуулж байна. Энэ жилийн хөрсний өдрийн онцлог нь хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хөрсний тогтвортой менежментийг хэрэгжүүлэх бодлогын шийдвэрт хөрсний үнэн зөв өгөгдөл, мэдээллийн ач холбогдол чухал юм.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17) 2026 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо зохион байгуулагдахад Монголын хөрс судлаач, эрдэмтдийн оролцоог хангах, Монгол орны цөлжилт, газрын доройтлын хэлбэр бүрийг бодитоор үнэлэх, үржил шимийн доройтолд өртсөн хөрсийг нөхөн сэргээх шинэ санаачлаг, хөрс хамгаалах эрх зүйн боломж зэрэг асуудлуудыг энэхүү хурлаар нэгтгэн дүгнэж, хэлэлцэхээр зорин ажиллаж байна.

Монгол улс газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхийн тулд 2030 он гэхэд нэг тэрбум мод тарих зорилготой Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнүүдийн хэрэгжилтийг хангахад хөрс хамгаалал, түүний эрх зүйн орчны шинэчлэлийн асуудал чухал юм. Тус салбарын эрхзүйн асуудалд шинжлэх ухааны үндэстэй, олон талын оролцоог хангах нь хөрс хамгаалах, хөрс судлалын салбарын асуудлыг зөв тодорхойлох, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлого, эрх зүйн шинэчлэлийг хийх боломжуудыг энэхүү уулзалт, хэлэлцүүлгээр бүрдэнэ гэж найдаж байна.

Энэ жилийн хувьд “Монгол орны хөрс судлал-2024” эрдэм шинжилгээний хурлыг “Хөрс хамгааллын бодлого, хөрсний тогтвортой менежмент” сэдвийн хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, ШУА-ийн Газарзүй геоэкологийн хүрээлэн, Монголын хөрс судлалын холбоо, БОУАӨЯ, ХХААХҮЯ зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна.

Зорилго:

Манай орны хөрс хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, хөрсний мониторинг, хөрсний мэдээллийн сан, хөрсний дижитал зураглал, хөрсний доройтол болон бохирдол, бэлчээр болон тариалангийн хөрсний элэгдэл, хөрс нөхөн сэргээх технологи зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй, үр дүн хэлэлцэх, туршлага солилцох, хөрс хамгаалах, газрын доройтлыг тэглэхэд төр засгаас баримталж буй бодлого шийдвэрт хөрсний тогтвортой менежментийн ач холбогдлыг ойлгуулах, зөвлөмж хүргүүлэх нь уг хурлын үндсэн зорилго оршино.

Ерөнхий зохион байгуулагч:

Монгол улсын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэн

Хамтран зохион байгуулагч:

Хөрс судлалын холбоо, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Оролцогч байгууллага:

Нийслэлийн байгаль орчны газар, Ургамал газар тариалангийн хүрээлэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Нийслэлийн эрүүл мэндийн хүрээлэн болон бусад аж ахуйн нэгжүүд оролцоно.

Хурлын үр дүн:

Эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 09:00 цагт МУИС-ийн Номын сангийн 502 хурлын танхимд эхлэн нийт 10 гаруй байгууллагын эрдэмтэн, судлаач, зөвлөх, мэргэжилтнүүд оролцож илтгэл тавьж, хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнгээр зөвлөмж боловсруулна. Бид энэхүү хурлыг зохион байгуулснаар дараах үр дүнд хүрэхээр зорьж байна.

- 🌱 Монгол орны хөрсний төлөв байдал, үржил шимийн талаарх илтгэлүүдийг хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох,
- 🌱 Хөрсний талаар хийгдсэн өндөр ач холбогдолтой судалгааны ажлын үр дүнг олон нийтэд хүргэх,
- 🌱 Монгол орны хотжилт, уур уурхай, хүний үйл ажиллагаагаар хөрсөн орчинд гарч буй өөрчлөлт, бохирдол, нөхөн сэргээхэд авах арга хэмжээг тодорхойлох,
- 🌱 Хөрс хамгаалал, нөхөн сэргээх технологи түүнтэй холбоотой судалгааны үр дүнг хэлэлцэж, энэ талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлох,
- 🌱 Хөрс хамгааллын эрх зүйн шинэчлэлийн талаар хэлэлцэж, зөвлөмжид тусгах,
- 🌱 Хуралд тавигдсан илтгэл болон хурлаас гарсан санал, санаачилгаар зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.

Хуралд тавигдах илтгэлийн ерөнхий чиглэл:

- Монгол орны хөрс судлалын шинжлэх ухааны чиг хандлага
- Монгол орны хөрсний үржил шим, эрүүл ахуй, чанарын өөрчлөлт
- Монгол орны хөрсний доройтол, бохирдол, нөхөн сэргээх технологи
- Монгол орны тариалан, бэлчээр, газрын сангийн хөрсний мониторинг
- Хөрс хамгаалал, бордоо үйлдвэрлэлийн эрх зүйн орчин

“МОНГОЛ ОРНЫ ХӨРС СУДЛАЛ – 2024”

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

2024.12.05 (ПҮРЭВ ГАРАГ), 09:00-15:30

МУИС-ИЙН НОМЫН САН 502 ХУРЛЫН ТАНХИМ

08:30-09:00 Бүртгэл

09:00-09:30

НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Г. Энхмөнх

Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Ц. Уранчимэг

Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

Ч. Сономдагва

Инженер, технологийн сургуулийн захирал, Монгол улсын их сургууль

А. Буянбаатар

Агроэкологийн сургуулийн захирал, Хөдөө аж ахуйн сургууль

А. Дашцэрэн

Газарзүй-Геоэкологийн хүрээлэн захирал, Монгол улсын шинжлэх ухааны академи

Ц. Баатарчулуун

Байгалийн ухааны салбар хариуцсан дэд захирал, Монгол улсын их сургууль

09:30-10:30

ҮНДСЭН ИЛТГЭЛ

Монгол орны хөрс судлалын боловсрол

Д. Даваадорж, Дэд профессор, МУИС, Шинжлэх Ухааны Сургууль

Монгол орны тариалангийн хөрсний судалгаа

А. Буянбаатар, Дэд профессор, ХААИС, Агроэкологийн сургууль

Монгол орны хөрс судлалын шинжлэх ухааны чиг хандлага

Ө. Ганзориг, Салбарын дарга, ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн

Монгол орны хөрсөн орчинд тулгамдаж буй асуудлууд

Ц. Батчулуун, Дэд профессор, МУИС, Инженер, Технологийн Сургууль

10:30-10:45

ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА, ҮЗЭСГЭЛЭН

САЛБАР ХУРАЛДААН: МОНГОЛ ОРНЫ ХӨРС ХАМГААЛАЛ, ХӨРСНИЙ ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭ

10:45-12:30

Модератор: Ц. Батчулуун, Дэд профессор, Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн эрхлэгч, ИТС, МУИС

Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх хуулийн хэрэгжилтийн судалгаа

Б. Одгэрэл, Профессор, ХААИС, Агроэкологийн сургууль

Монгол орчны хөрсний доройтлыг бууруулахад тогтвортой хөрсний менежментийг хэрэгжүүлэх бодлого, зөвлөмж

Б. Нямдаваа, Дэд профессор, МУИС, Шинжлэх Ухааны Сургууль

Хөрсний тогтвортой менежмент

Б. Энхтуяа, Дэд профессор, Дархан ХААИС

Уур амьсгалын өөрчлөлт болон мал бэлчээрлэлтийн бэлчээрийн төлөв байдалд үзүүлэх нөлөө

Ц. Бат-Оюун, Доктор, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн

Монгол орны ойн хөрсний органик нүүрстөрөгчийн нөөцийн өөрчлөлт

Г. Бямбаа, ЭША, ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн

Тариалангийн газрын хөрсний чанарын үнэлгээ

Д. Бямбасүрэн, Багш, ХААИС, Агроэкологийн сургууль

Монгол улсын газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторинг

Б. Дөл, Газрын мониторингийн хэлтсийн дарга, ГЗБГЗЗЕГ

12:30-13:00

ҮДИЙН ЗАВСАРЛАГА, ҮЗЭСГЭЛЭН

13:00-15:00

САЛБАР ХУРАЛДААН: МОНГОЛ ОРНЫ ХӨРСӨН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, БОХИРДОЛ, НӨХӨН СЭРГЭЭХ ТЕХНОЛОГИ

Модератор: Ө. Ганзориг, Хөрс судлалын салбарын дарга, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, ШУА

Хөрсний бохирдлыг бууруулах бодлого, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

С. Шинэзул, Хөрсний бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар, БОУАӨЯ

Улаанбаатар хотын өнгөн хөрсний хүнд металлын бохирдол, бууруулах судалгаа

Ц. Соёл-эрдэнэ, Профессор, МУИС, Инженер, Технологийн Сургууль

Орхон аймгийн сургууль орчмын өнгөн хөрс болон тоосонцорт агуулагдах хүнд металлын судалгаа

Б. Батдэлгэр, Дэд профессор, МУИС, Инженер, Технологийн Сургууль

Улаанбаатар хотын хөрсний бохирдлыг судалсан дүн

Н. Дамбадаржаа, Доктор, ХААИС, Агроэкологийн сургууль

Эрдэнэт хотын хөрсөнд агуулагдах Cr, Co, Ni, Ga, Mo, Cd, Sn-ийн бохирдлоос үүсэх хүний эрүүл мэндийн эрсдэлийг тооцох нь

Б. Дөлгөөн, ЭША, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Хөрсний биологийн идэвхэд бордооны төрлүүдийн нөлөө

Г. Батцэцэг, ХААИС, Агроэкологийн сургууль

Хөрсний бактерийн бүлгэмдэл, олон янз байдал, экзополисахарид нийлэгжүүлэх чадварыг Монгол орны хур тунадасны градиентын дагуу судалсан үр дүн

Д. Пунсалдулам, ЭША, ШУА, Биологийн хүрээлэн

Баруун бүсийн жимс жимсгэнэ тариалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Г. Баянмөнх, ХААИС, Агроэкологийн сургууль

15:00-15:30

ХААЛТЫН АЖИЛЛАГАА

САЛБАР ХУРАЛДААНЫ ҮР ДҮН, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Салбар хуралдаан: Монгол орны хөрс хамгаалал, хөрсний тогтвортой менежментийн арга хэмжээ

А. Буянбаатар, Дэд профессор, Агроэкологийн сургуулийн захирал, ХААИС

Салбар хуралдаан: Монгол орны хөрсөн орчны өөрчлөлт, бохирдол, нөхөн сэргээх технологи


Д. Даваадорж, Дэд профессор, Газарзүйн тэнхим, ШУС, МУИС

ХУРЛЫН ХААЛТ

Б. Нямдаваа

Дэд профессор, Геопедологийн лабораторийн эрхлэгч, Газарзүйн тэнхим, ШУС, МУИС

ТЭМДЭГЛЭЛ



ТЭМДЭГЛЭЛ

